



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/658

Хэрлэн сум

“Ахуйн үйлчилгээ-2024” өдөрлөгийг зохион байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 2023 оны аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хорин гуравдугаар хуралдааны “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 02 дугаар, “Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Ахуйн үйлчилгээний салбарт дэвшилтэт технологийг нэвтрүүлэн стандартад нийцсэн үйлчилгээг иргэдэд хүргэж, эрүүл ахуйн зохистой дадлыг нэвтрүүлж, тогтвортой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломжийг бүрдүүлэн ажиллаж байгаа ахуйн үйлчилгээний салбарын манлайлагчдыг нээлттэй сурталчлах зорилгоор “Ахуйн үйлчилгээ-2024” өдөрлөгийг 2024 оны 12 дугаар сарын 12-нд Чингис хотод зохион байгуулахад 3,500,000 (гурван сая таван зуун мянган) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.


2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Өдөрлөгийг үр дүнтэй зохион байгуулж тайлагнаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантөмөр)-д, арга хэмжээнд шаардагдах зардлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зөвлөгөөн хэрэгжүүлэх зардлаас 2,000,000, “Нээлттэй Хэнтий аймаг” хөтөлбөрийн хөрөнгөөс 1,500,000 төгрөгийг тус тус санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ





Аймгийн Засаг даргын 2024 оны
12 дугаар сарын 13-ний өдрийн
1658 дугаар захирамжийн хавсралт

"АХУЙ ҮЙЛЧИЛГЭЭ- 2024" ӨДӨРЛӨГИЙН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Заалны түрээс	тоо	1	1,500.000	1,500.000	
2	Үдийн цай	тоо	40	50,000	2,000.000	
	БҮГД ҮНЭ				3,500.000	